



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2023 оны ээлжит 13 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар Радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч (яриа, дата, мессеж) нарын харилцан холболтын чиглэлээр батлагдсан зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай танилцуулга (Хорооны 2023 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэл); “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах” төслийн явцын тухай танилцуулга; “Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ын баримт бичгийн төслийн тухай; Телевиз, радиогийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайлан (2023 оны эхний хагас жилийн байдлаар); Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт); Хорооны тогтоолоор шинээр ТЗ олгосон боловч гэрчилгээ аваагүй, гэрээ байгуулаагүй зэрэг зөрчилтэй ААН-ын судалгаа, зөвшөөрлийг цуцлах санал дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 8 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 06 дугаар (2023-05-31) хуралдаанаар Монгол Улсын нутаг дэвсгэрт радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ (яриа, дата, мессеж) эрхлэгчдийн харилцан холболтын чиглэлээр батлагдсан журам, зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлттэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ажлын хэсгийн тайланг сонсоод, энэхүү асуудлаар Хорооны хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Шалгалтын тайлан, дүгнэлттэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр Тэмдэглэл гаргаж, холбогдох ажлын хэсэгт удирдамж чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосон юм. Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны А/129 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсгээс харилцан холболтын чиглэлээр батлагдсан журам, зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах, дүгнэлт өгөх зорилго бүхий хяналтын үйл ажиллагааг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 10-ны өдрийг дуусах хүртэл хугацаанд хийж гүйцэтгэжээ. Ажлын хэсгээс тус хуралдаанд зохицуулах хорооны хуралдааны 2023 оны 04 дүгээр Тэмдэглэлийн заалт бүрээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд болон Радио давтамж ашиглан харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ эрхлэгч (яриа, дата, мессеж) нарын харилцан холболтын чиглэлээр батлагдсан зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн тухай танилцуулга, харилцан холболтын чиглэлээр батлагдсан журам, зохицуулалтын баримт бичгийн

хэрэгжилтийн байдал, ажлын хэсэг үйлчилгээ эрхлэгчдийн зааглах цэгийн байршил, мэдээлэлтэй танилцах, газар дээр нь очиж ажиллаж, сүлжээний техник тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээлэлд үндэслэн харилцан холболт хийхэд техник, технологийн бэлэн байдлын үнэлгээ, шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Хуралдаанаас ажлын хэсгийн тайлан, холбогдох зөвлөмжийн хамт шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдэд тус тус хүргүүлэх, санал дүгнэлтэд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгов.

Тус хуралдаанаар Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр ХХЗХ-нд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах” төслийн явцын тухай танилцуулгыг сонсож, төслийн зээлийн эргэн төлөлтийн хуваарь, ирэх жилийн төсөвт тусгах тооцоолол, төлөвлөлт болон техник эдийн засгийн үндэслэл, техникийн шийдэл, байршлын талаар мэдээллийг боловсруулан Хорооны хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг Радио давтамжийн зохицуулалт, хяналт газар /З.Амгалан/, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т тус тус үүрэг болгов.

Радио долгионы тухай хуулийн 5.2.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг шинэчлэн баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 6240 дугаарт бүртгүүлэн мөрдөж байна. Уг баримт бичгийн хүснэгтийн 4 дэх хэсэг VHF буюу хэт богино долгионы зурвас (30-300 МГц)-ын царааны 76-87.5 МГц-ийн давтамжийн зурвасыг *“өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад ашиглана”*, тусгай нөхцөл нь *“Хэт богино долгионы (FM) радиогийн өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах үйлчилгээнд сонгон шалгаруулалтын журмаар олгоно”* гэж тус тус тодорхойлон заасан. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup>.1.2 хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нийцүүлэн тус хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 88 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, улмаар ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлсэн болно. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хорооны Даргын 2023 оны А/246 тоот тушаалаар “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад олгох радио давтамжийн сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт FM радиогийн сонсогдолтын цар хүрээ, хүртээмж, радио нэвтрүүлэгчийн хамрах хүрээ, хэрэглэгч сонсогчийн тоог нэмэгдүүлэх, тухайн салбарын зах зээл, бизнесийн орчныг сайжруулах, өрсөлдөөнийг бий болгох, ялгаварлалгүй, эрх тэгш, шударга байх зарчмыг баримталсан ба үнэлгээний шалгуур үзүүлэлтийг Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт заасны дагуу “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад олгох радио давтамжийн сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг баримт бичгийн төслийг боловсруулжээ. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаанд ажлын хэсгээс боловсруулсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад олгох радио давтамжийн сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг баримт бичгийн танилцуулга, тогтоолын төсөл,

хавсралт баримт бичгийн төслийг хэлэлцээд, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.2</sup>, 5<sup>1.1.11</sup> дэх заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 113 тоот “Сонгон шалгаруулалт зохион байгуулах, баримт бичиг батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан. Уг тогтоолд, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг зарлах, “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг баталж, энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний хороо байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгов.

Тус хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаанд ӨНЗГ-аас арилжааны, Улаанбаатар хот, орон нутгийн телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайлан (2023 оны эхний хагас жилийн байдлаар)-г танилцуулав. Тайлант хугацаанд мониторингийн үйл ажиллагаанд хамрагдсан радио, телевизүүдийн хөтөлбөр, зар сурталчилгаанд тавигдах шаардлагын хэрэгжилтийн байдалд авч буй арга хэмжээний хүрээнд ХХЗХ-ны 2023 оны сэтгүүл, цахим хуудаст телевизүүдийн хөтөлбөрийн мониторингийн сар бүрийн мэдээлэл, тайланг тогтмол нийтэлж, арилжааны 16 телевизэд давхардсан тоогоор 30 удаа хугацаатай үүрэг даалгавар бүхий албан тоот, орон нутгийн телевизүүдийн үндэсний бүтээлийн хувь 50%-с доош байгаа орон нутгийн 4 телевизэд шаардлага хүргүүлэн биелэлтийг хянан ажиллаж, илэрсэн зөрчлийг хугацаанд нь арилгаагүй нэр бүхий 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг боловсруулан тухай бүр хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж ажилласан болно.

Энэхүү хорооны 2023 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Хорооны тогтоолоор ТЗ олгосон боловч гэрчилгээ аваагүй, гэрээ байгуулаагүй зэрэг зөрчилтэй ААН-ын судалгаа, зөвшөөрлийг цуцлах санал дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 114 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 115 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 116 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 117 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 118 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 119 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 1 дугаар ашиглалтын хугацааг сунгасан;
- Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн тус хорооны тогтоолоор тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэр гарсан боловч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, гэрчилгээ аваагүй 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 120 тоот тогтоолын хавсралтад заасан нэр бүхий 3 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоолын тухайн хуулийн этгээдэд холбогдох хэсгийг цуцалж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2023-10-06